

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Үнэт цаас гаргагчийн нэр: <b>Монложистике холдинг ХК</b> Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: <b>6381251</b> Үнэт цаасны код: <b>MN00MLG05696</b> Утасны дугаар: <b>7701-5454</b>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Тээврийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	395,858,822
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: З.Шинэ-Од /Санхүү эрхэлсэн захирал/ Хянасан: Г.Хишигбат /Гүйцэтгэх захирал/

1. Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

	Мянган төгрөгөөр	2023 он	2024 он
		12-р сарын 31	6 сарын 30
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн	53,116,441	77,092,828
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,397,151	8,829,794
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>61,513,592</b>	<b>85,922,623</b>
	Өр төлбөрийн нийт дүн	27,301,241	38,168,329
	Эздийн өмчийн дүн	34,212,351	47,754,294
	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>61,513,592</b>	<b>85,922,623</b>
	Орлогын тайлан	Мянган төгрөгөөр	2023 он 12-р сарын 31
Борлуулалтын орлого		95,243,684	141,982,228
<b>Нийт ашиг</b>		<b>10,107,418</b>	<b>11,717,833</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>		<b>5,478,049</b>	<b>7,589,518</b>
Орлогын татварын зардал		582,970	(943,316)
<b>Татварын дараах ашиг</b>		<b>6,061,019</b>	<b>6,646,202</b>

		Мянган төгрөгөөр	2023 он 12-р сарын 31	2024 он 6 сарын 30												
Өмчийн өөрчлөлтийн тайлан		Өмч	118,758	118,758												
		Халаасны хувьцаа	-	-												
		Нэмж төлөгдсөн капитал	10,187,611	10,187,611												
		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(211,818)	(176,546)												
		Хуримтлагдсан ашиг	29,190,901	31,474,115												
		Нийт дүн	39,285,452	41,603,938												
		Хяналтын эрхгүй хувь оролцоо	4,154,032	6,150,356												
		Нийт дүн	43,439,484	47,754,294												
		Мөнгөн гүйлгээний тайлан		Мянган төгрөгөөр	2023 он 12-р сарын 31	2024 он 6 сарын 30										
Өмч	118,758			118,758												
Халаасны хувьцаа	-			-												
Нэмж төлөгдсөн капитал	10,187,611			10,187,611												
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(211,818)			(176,546)												
Хуримтлагдсан ашиг	29,190,901			31,474,115												
Нийт дүн	39,285,452			41,603,938												
Хяналтын эрхгүй хувь оролцоо	4,154,032			6,150,356												
Нийт дүн	43,439,484			47,754,294												
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт															
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт															
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Монложистикс групп нь нэгтгэсэн тайлангаар 2024 оны 2-р улирлын байдлаар 6,6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Тайлант хугацааны нэгж хувьцаанд ногдох татварын дараах ашиг (EPS) 12.67 төгрөг байна. Нийт актив 85,9 тэрбум, нийт өр төлбөр 38,1 тэрбум, эздийн өмчийн тайлан 47,7 тэрбум төгрөг хүрч 39%, 39%, 39% тус тус хувиар өнгөрсөн оноос өссөн байна.														
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table border="1"> <thead> <tr> <th>Харьцаанууд</th> <th>2023 он 12-р сарын 31</th> <th>2024 он 6 сарын 30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td> <td>3.26</td> <td>2.19</td> </tr> <tr> <td>Түргэн хөрвөх чадварын харьцаа</td> <td>3.25</td> <td>1.47</td> </tr> <tr> <td>Өрийн харьцаа</td> <td>0.44</td> <td>0.44</td> </tr> </tbody> </table>			Харьцаанууд	2023 он 12-р сарын 31	2024 он 6 сарын 30	Эргэлтийн харьцаа	3.26	2.19	Түргэн хөрвөх чадварын харьцаа	3.25	1.47	Өрийн харьцаа	0.44	0.44
Харьцаанууд	2023 он 12-р сарын 31	2024 он 6 сарын 30														
Эргэлтийн харьцаа	3.26	2.19														
Түргэн хөрвөх чадварын харьцаа	3.25	1.47														
Өрийн харьцаа	0.44	0.44														

3.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p><b>Тианжин боомт:</b> Импортын гол ачаа тээвэр дамжин өнгөрдөг Тианжин боомтод ачаа бараа бөөгнөрч тээврийн хугацаа 40-с дээш хонгоор нэмэгдэж байна. Энэхүү эрсдлийг бууруулах үүднээс харилцагч нарыгаа авто замаар ачаа барааг импортлох дээр чиглүүлж байна.</p> <p><b>Транзит тээвэр:</b> Сүүлийн жилүүдэд хөрш 2 орны хооронд дамжин өнгөрч буй тээврийн хэмжээ нэмэгдсээр байна. Хэдий тийм ч ОХУ-н эсрэг хориг хэмжээнээс хамаарч ОХУ холбоотой ажил гүйлгээ хийх боломж багасаж, хугацаа өртөг нэмэгдэж байна. Тийм учраас Монложистике групп нь хориг арга хэмжээнд орсон байгууллага, хувь болон бараа үйлчилгээнээс бүрэн татгалзаж байна. Мөн Монложистике групп нь хориг арга хэмжээнд орох эрсдлийг бууруулах үүднээс олон улсын хоригт орсон аливаа харилцагч, бараа үйлчилгээг хянаж шалгадаг алхамуудыг тодорхойлон ажиллаж байна.</p> <p><b>Шинэ сегмент:</b> Импортын ачаа тээврийн томоохон бүрдэл болох автомашины тээврийн сегмент хурдан шуурхай нэвтрэх үүднээс Төв Азийн Зам ХХК-ийн 51%-г худалдаж аваад байна. Энэхүү компани нь тус зах зээлд өндөр туршлагатай, сүүлийн жилүүдэд хурдтай хөгжиж буй компани юм.</p>																
3.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</p>	<p>2024 онд Нягтлан бодох бүртгэлд өөрчлөлт ороогүй. Тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй байна.</p>																
4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>																	
	<p>2024 оны эхний 2 улиралд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сонирхлын зөрчилтэй: Монложистике холдинг - Охин компаниудтай “Менежментийн үйлчилгээний гэрээ” байгуулсан</li> <li>- Их хэмжээний хэлцэл: Монложистике экүйпмент - Вагон нийлүүлэх гэрээ – РМ Рейл Азия</li> <li>- Их хэмжээний хэлцэл: Монложистике экүйпмент - Зээлийн гэрээ - ИВЕС</li> </ul>																	
5.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</p>																	
	<p>Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө</p>	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr style="background-color: #e91e63; color: white;"> <th style="text-align: left;">№</th> <th style="text-align: left;">Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын Төлөвлөгөө</th> <th style="text-align: left;">Зарцуулалт</th> <th style="text-align: left;">Үлдэгдэл</th> </tr> <tr> <th colspan="4" style="text-align: left;">Дүн (сая.төгрөг)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center;">1</td> <td>Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт</td> <td style="text-align: center;">8,062</td> <td style="text-align: center;">398</td> </tr> <tr> <td></td> <td></td> <td></td> <td style="text-align: center;">4,164</td> </tr> </tbody> </table>	№	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл	Дүн (сая.төгрөг)				1	Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	398				4,164
№	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл															
Дүн (сая.төгрөг)																		
1	Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	398															
			4,164															

	<table border="1" data-bbox="263 91 1284 291"> <tr> <td data-bbox="263 91 869 168">2</td> <td data-bbox="869 91 1029 168">Эргэлтийн хөрөнгө</td> <td data-bbox="1029 91 1141 168">2,923</td> <td data-bbox="1141 91 1284 168">2,878</td> <td data-bbox="1284 91 1511 168">45</td> </tr> <tr> <td data-bbox="263 168 869 235">3</td> <td data-bbox="869 168 1029 235">Төв азийн зам</td> <td data-bbox="1029 168 1141 235"></td> <td data-bbox="1141 168 1284 235">3,500</td> <td data-bbox="1284 168 1511 235"></td> </tr> <tr> <td data-bbox="263 235 869 291"></td> <td data-bbox="869 235 1029 291">Нийт</td> <td data-bbox="1029 235 1141 291">10,985</td> <td data-bbox="1141 235 1284 291">6,778</td> <td data-bbox="1284 235 1511 291">4,207</td> </tr> </table> <p data-bbox="263 291 1511 347">1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт</p> <p data-bbox="263 347 1511 526">Экспортын тээврийн үйл ажиллагааг өргөжин тэлэхэд зориулж 2 цуваа буюу 100 ширхэг 13-6953 загварын тавцант вагоныг ОХУ-аас худалдан авахаар төлөвлөсөн. Энэхүү төлөвлөгөө нь Төмөр замын тухай хуулийн хойшилж, мөн ОХУ-аас вагон худалдан авах үйл ажиллагаанд учирч буй саад бэрхшээлээс үүдэн вагоны хөрөнгө оруулалтын хугацаа, вагоны төрөлд өөрчлөлт оруулсан.</p> <p data-bbox="263 526 1511 616">Эхний 10 ширхэг 12-1293 загварын хагас вагон нь 2024 оны 8-р сард орж ирэхээр байна. Дараагийн 40 ширхэг вагон гэрээ хэлэлцээрийн шатанд явагдаж байна.</p> <p data-bbox="263 616 1511 795">2024 оны эхний хагас жилийн байдлаар эхний 10 ширхэг вагон нь нийт 2.4 тэрбум төгрөгийн өртөгтэй хөрөнгө оруулалтын 1,6тэрбум зээлээр бусад 0,45 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулагдсан байна. Үлдэгдэл төлбөр вагон монгол улсад орж ирснээр төлөгдөхөөр байна.</p> <p data-bbox="263 795 1511 851">2. Эргэлийн хөрөнгийн санхүүжүүлэлт</p> <p data-bbox="263 851 1511 996">Охин компаниудын өсөлтийг хангахын тулд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 2,9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.</p> <p data-bbox="263 996 1511 1052">3. Шинэ бизнес: М&amp;А - Төв Азийн Зам ХХК</p> <p data-bbox="263 1052 1511 1294">Монложистикс групп нь зах зээл дээр хэдийн байршсан компани худалдан авах замаар зах зээлд эзлэх байр сууриа тэлэхээр сүүлийн жилүүдэд хурдтай өсөж буй ТЭСО группийн охин компани болох Төв Азийн Зам ХХК-ний 51%-ийг худалдан авахад 3,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулагдсан байна.</p>	2	Эргэлтийн хөрөнгө	2,923	2,878	45	3	Төв азийн зам		3,500			Нийт	10,985	6,778	4,207
2	Эргэлтийн хөрөнгө	2,923	2,878	45												
3	Төв азийн зам		3,500													
	Нийт	10,985	6,778	4,207												
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл															
	<p data-bbox="263 1350 1511 1406">Засаглалын бүтэц, үйл ажиллагаа</p> <p data-bbox="263 1406 1511 1462"><b>I. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал</b></p> <p data-bbox="263 1462 1511 1664">Монложистикс Холдинг ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 85.57%-ийн ирцтэйгээр хуралдсан. Хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хуралд:</p> <p data-bbox="263 1664 1511 1852">1. Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г. Хишигбат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг товч танилцуулж;</p>															

2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг компанийн ТУЗ-ийн цалингийн төсвийг хэлэлцэж батлахын өмнө компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж;
3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцсон.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар:

1. Монложистикс Холдинг ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батласан.
2. Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батласан.

## **II. Төлөөлөн удирдах зөвлөл**

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм. Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 5, хараат бус 4, нийт 9 гишүүнтэй.

ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсөв:

№	Зардлын задаргаа	Нийт зардал
1	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал	182,400,000 ₮
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	22,800,000 ₮
	<b>НИЙТ ЗАРДЛЫН ТӨСӨВ</b>	<b>205,200,000 ₮</b>

## **III. Хяналт**

### **Комплайнсын хяналт**




Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниудын үйл ажиллагаа болон дотоод хэм хэмжээний актуудыг хууль, эрх зүйн хэм хэмжээнд хянан нийцүүлэх замаар хууль эрх зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн гарах эрсдэлүүдээс сэргийлэх, компанид комплайнсын соёлыг бүрдүүлж төлөвшүүлэх зорилготой “Нийцлийн журам” 2024 оны 2 дугаар сард шинэчлэгдэн батлагдсан.

Компани үйл ажиллагаандаа олон улсын чанарын ISO9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2024 оны 3-6 дугаар саруудад Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниудын үйл ажиллагаа болон дотоод хэм хэмжээний актууд нь хууль, эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг үнэлж, Нийцэл хариуцсан ажилтан үнэлгээг хянан баталгаажуулж, үл нийцэл бүрд залруулах арга хэмжээний зөвлөмж гаргалаа.

2024 оны сүүлийн хагас жилд Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниуд нь үл нийцлийг үе шаттайгаар залруулах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

## **IV. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, өөрийн үнэлгээ**

### **Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт**

	<p>Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бий болгох, компанийг эрдэлээс хамгаалж, тогтвортой үнэ цэнийг бүтээх чухал ач холбогдолтой засаглалын бодлогын бичиг баримтуудыг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилд дараах журмуудыг шинээр баталсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам,</li> <li>▪ Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого</li> </ul>
7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл
	<p><b>Мэдээллийн ил тод байдал</b></p> <p>Монложистике Холдинг ХК нь ил тод байдлын зарчмыг баримтлан, олон нийтэд нээлттэй мэдээлэх тухай зохицуулагч байгууллагуудын шаардлагад нийцүүлэн хөрөнгө оруулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж, компанийн цахим хуудсаар болон Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр нийтэд мэдээлж байна.</p> <p><b>Компанийн засаглал</b></p> <p>Монложистике Холдинг Хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсанаар компанийн дүрмийг шинэчлэн баталж, бүртгэлийн байгууллагаар баталгаажуулсан. Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн тусгай зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодескийн шаардлагад нийцүүлэн хувьцаат компани болсонтой холбогдуулан Монложистике Холдинг ХК-ийн засаглалын дараах бодлого, журмуудыг шинээр болон шинэчлэн баталсан.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монложистике Холдинг ХК-ийн Нэгдэл ашгийн бодлого</li> <li>2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам</li> <li>3. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам</li> <li>4. ТУЗ-ийн дэргэдэх Хороодын үйл ажиллагааны журам</li> <li>5. Нийцлийн журам</li> </ol> <p>Цаашид өмнө батлагдсан байсан журмуудыг үе шатайгаар шинэчлэн сайжруулах, шинээр журмууд боловсруулж батлуулахаар төлөвлөсөн бөгөөд энэхүү процесс явагдаж байна.</p>
Мэдээлэл бэлтгэж, хүргүүдсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2024-07-20	
Овог, нэр: З.Шинэ-Од	
Албан тушаал: Санхүү эрхэлсэн захирал	
Гарын үсэг:	

# 2024 он ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

## АГУУЛГА




БИДНИЙ  
ТУХАЙ



СТРАТЕГИ  
БОЛОН  
САНХҮҮГИЙН  
ЗОРИЛГО



БИДНИЙ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖИЛ



ЗАСАГЛАЛ



САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН





**monlogistics**  
GROUP

**01**

**БИДНИЙ ТУХАЙ**



## КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс Групп нь 2005 онд тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө 1 толгой компани, 10 охин компани, 210 орчим ажилтан, 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол улсын тээврийн салбарын тэргүүлэгч байгууллага болсон байна.

Монложистикс Групп нь Монгол Улсын иргэдийн өдөр тутам хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уул уурхайн түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлох, хөрш орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг зэрэг тээвэр ложистикийн бүх төрлөөр олон улсын стандартад нийцсэн тээврийн цогц үйлчилгээг үзүүлсээр байна.

Монложистикс Холдинг ХК нь тээвэр ложистикийн цогц үйлчилгээ үзүүлэгч Группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, тэдгээрт Хүний нөөц, Санхүү, Мэдээллийн технологи, Маркетинг, Стратеги, бизнес хөгжил, Ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.

## Эрхэм зорилго

Дэлхий рүү тэмүүлэх үндэсний брэнд

## Алсын хараа

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.

## Үнэт зүйлс

Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтэл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.

Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.

Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.


Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.

# ГРУППИЙН БҮТЭЦ



\*2024.01.01 -ний өдрөөс “Төв Азийн Зам” ХХК-г нэгтгээнд тооцно

## ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол улсын тээврийн салбарын орлогын өсөлт

^ **+25%**

---

Монложистикс Групп Борлуулалтын орлогын өсөлт

^ **+55%**

---

Монложистикс Групп цэвэр ашгийн өсөлт

^ **+45%**

---

Монложистикс Группийн тээвэрлэсэн ачааны өсөлт

^ **+13%**

Монложистикс Групп экспортын ачаа тээврийн өсөлт

^ **+21%**

---

Монложистикс Групп импортын ачаа тээврийн өсөлт

^ **+15%**

---

Монложистикс Групп транзит ачаа тээврийн өсөлт

^ **+11%**



## ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ





Монложистикс Транзит  
ХХК байгуулагдав.

2019 ОН



Порфолио өргөжилт хийж,  
3 охин компаниа байгуулав.

2021 ОН



Монложистикс Холдинг  
ХХК Олон нийтэд  
нээлтэй компани  
болов.

2023 ОН



Төв азийн зам ХХК-ийн  
51%-ийг өөртөө нэгтгэлээ.

2024 ОН

2018 ОН

Оюу толгой компанийн  
албан ёсны тээврийн  
компаниар шалгарав.



2020 ОН

Монложистикс Холдинг ХХК  
Толгой компани байгуулагдав.



2022 ОН

Түүхий эдийн экспортын  
тээврийг эхлүүлж,  
Каус Аустралис ХХК-ийг  
байгуулав.



2023 ОН

Do good HUB ТББ-ыг байгуулав.



## ОНЦЛОХ ТЭЭВЭР



### Монложистикс Ворлдвайд ХХК

Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн төслийн ачаа болох Трансформатор тоног төхөөрөмжийг тээвэрлэлээ. Тус тээвэр нь эмзэг, доргилт мэдрэгч суурилуулсан, хурдны хязгаар заасан онцлогтой ачаа бөгөөд хийн нумтай авто машинаар амжилттай тээвэрлэж гүйцэтгэсэн байна.



### Монложистикс Ворлдвайд ХХК

Монголын Мянган сорилтын сангийн “Гэр хорооллын ус түгээх байр автоматжуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулах” төслийн ачаануудыг сүүлийн 10 сарын хугацаанд амжилттай тээвэрлэж гүйцэтгэж байна.



### Монложистикс Транзит ХХК

2024 оны 5-р сард анх удаа транзит тээвэрээр тоног төхөөрөмж амжилттай тээвэрлэлээ. Тус тээвэрлэлтээр 45.700, 54.312 кг-ын жинтэй тоног төхөөрөмжүүдийг тус тус ОХУ-ын Никель өртөө рүү тээвэрлэлээ.



## ОНЦЛОХ ТЭЭВЭР



### Монложистикс Тракинг ХХК

Монложистикс Группийн 2030 Алсын харааны нэг хэсэг болох дэд бүтцийн төслүүдийг эхлүүлэх зорилтын хүрээнд Монложистикс Тракинг ХХК Улаанбаатар хотод чингэлэг хадгалалт, агуулах терминалын үйлчилгээг 2024 оны 4 сараас эхлэн үзүүлж эхэллээ. Ингэснээр “хаалганаас хаалганд” цогц үйлчилгээг үзүүлэх дэд бүтцийг бий болгож, борлуулалтын сүвгийг өргөжүүлсэн үйл явдал боллоо.



### Монложистикс Карго ХХК

Монложистикс Карго компанийн цахим худалдааны платформ болох Cheerah Brand энэ оны 6-р сард 120,000 хэрэглэгчтэй боллоо. Өнгөрсөн 3-р сард “Бодит Болго” шинэ үйлчилгээг Монголд анх удаа амжилттай нэвтрүүлсэн юм. Тус үйлчилгээ нь илүү хурдан, хялбар байдлаар үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ хүссэн барааг нь хэрэглэгчдэдээ хурдан шуурхай олж өгдөг онцлогтой.



### Монложистикс Транс Сервис ХХК

2024 оны 5-р сард ОХУ-ын экспорт, импорт, дотоодын тээвэрлэлтэд техникийн нислэг хийх зориулалттай хаалттай вагоны тоог амжилттай нэмэгдүүлж ажиллалаа. Мөн экспортын чингэлэг тээвэрлэлтийг Клещиха (Орос) - Улаанбаатар чиглэлд амжилттай зохион байгуулсан байна.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### “Хөрөнгө оруулагчидтай харилцах” зөвлөх үйлчилгээг авч эхэллээ

Монложистикс Холдинг ХК нь нээлттэй компанийн хүрээнд хувьцаа эзэмшигчид болон хөрөнгийн зах зээлийн нийт оролцогчдод мэдээллээ илүү нээлттэй, ил тод хүргэж, тэдгээртэй хэрхэн зөв харилцаатай байх тал дээр онцгой анхааран ажиллаж байна. Үүний хүрээнд Монложистикс Холдинг ХК (MSE:MLG) нь хөрөнгө оруулагчидтай харилцах (Investor Relation) функцээ сайжруулах зорилгоор мэргэжлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний компани болох СММ Коммуникаци ба Адвайзорийс ХХК-тай хамтын ажиллагааг эхлүүлээ.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хөрөнгө оруулагчидтай харилцах суваг, календарь боловсруулах, хөрөнгө оруулалтын түүх, хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга, стратеги боловсруулах зэрэг цогц ажлууд хийгдэх юм.



### “Logistic Management System”-ийг амжилттай нэвтрүүллээ

Монложистикс Групп салбартаа түүчээлэн бүрэн дижитал шилжилт төслийг өнгөрсөн оноос эрчимтэй эхлүүлсэн. Уг төслийн хүрээнд 2024 оны 1 сараас дотооддоо хөгжүүлж эхэлсэн LMS/Logistic Management System/ төслийн анхны “LMS 1.0” хувилбарыг 6 сарын 3-нд Монложистикс Ворлдвайд ХХК-д, 6 сарын 18-нд Монложистикс Тракинг ХХК-д тус тус амжилттай нэвтрүүллээ. Үргэлжлүүлэн Монложистикс группийн бусад охин компаниудад LMS 1.0 хувилбарыг шат дараатай нэвтрүүлж дижитал шилжилтийг эрчимжүүлж байна.

Бид цаашид үйл ажиллагаандаа орчин цагийн программ хангамж, хиймэл оюун ухааныг шат дараатай нэвтрүүлж ложистикийн үйлчилгээг дараагийн төвшинд гаргах зорилт тавин ажиллаж байна.



### Вагон худалдан авалт хийгдэж эхэллээ

Монложистикс Групп богино болон дунд хугацааны стратеги бодлогын хүрээнд төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд хөрөнгө оруулалт хийх зорилтыг алсын хараа 2030-д тусгасан. Үүний хүрээнд 2 цуваа бүхий 100 вагон худалдан авах төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлж эхэллээ. Түүнчлэн IPO-ийн хүрээнд олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалт, бусад ажлуудыг төлөвлөгөөний дагуу шат дараатай хэрэгжүүлж байна.

Хөрш орон болоод дэлхийн геополитикийн асуудлуудтай тулгарч цаг хугацаа багагүй хойшилсон ч эхний ээлжийн 10 ширхэг 12-1293 загварын хагас вагон нь 2024 оны 8-р сард Монгол улсад импортлон орж ирэхээр байна. Дараагийн 40 ширхэг вагоны гэрээ хэлэлцээрийн шатанд явж байна.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### БНХАУ-ын Төрийн өмчит төмөр замтай хамтын ажиллагааны гэрээг байгууллаа

Монложистикс Групп нь China State Railway Group корпорацийн охин компани болох China Railway International Multimodal Transport Co.Ltd.-тэй олон талт стратегийн хамтын ажиллагааны гэрээг байгууллаа. Уг гэрээг байгуулснаар Монложистикс Групп нь Хятадын төрийн өмчит төмөр замын байгууллагатай илүү нягт хамтран ажиллаж, импорт, экспорт, транзит тээвэр хийж гүйцэтгэх мөн дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдэд хамтран хөрөнгө оруулах боломжууд нээгдэж байна.



### "Transport Logistic" 2024 арга хэмжээнд Монложистикс Группийн 4 компанийн төлөөлөл амжилттай оролцлоо.

БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдсан дэлхийн тээвэр, ложистикийн салбарын хамгийн том үзэсгэлэн, форум болох "Transport Logistic" 2024 арга хэмжээнд Монложистикс Группийн 4 компанийн төлөөлөл амжилттай оролцлоо.

Уг арга хэмжээ нь 2024 оны 6-р сарын 25-27-ны хооронд 3 өдрийн турш зохион байгуулагдсан ба дэлхийн олон улсын 680 гаруй тээврийн салбарын компаниуд мөн 20,000 гаруй хүн оролцсон байна.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

© hualonmultimodal.com

### Хувьцаа эзэмшигчдийн анхны ээлжит хурал амжилттай болж өнгөрлөө

Монложистикс Холдинг ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн анхны ээлжит хурал 2024 оны 4 сарын 27-ны өдөр цахим хэлбэрээр 85.57% ирцтэйгээр амжилттай болж өндөрлөлөө. Тус хувьцаа эзэмшигчдийн хурлаар Монложистикс Холдинг ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн төсвийг батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Монложистикс Холдинг ХК нь олон нийтэд нээлттэй компани болсноос хойших анхны ээлжит бус хурлыг өнгөрсөн оны 11-р сард хийж байсан билээ.



## МОНЛОЖИСТИКС ГРУПП ЭХНИЙ КОМПАНИА ХУДАЛДАЖ АВЛАА.

Монложистикс Групп тээвэр ложистикийн салбарт үйл ажиллагаа, бизнесийн цар хүрээгээ тэлж, ТЭСО Группийн охин компани болох “Төв Азийн Зам” ХХК-ийн хувьцааг худалдан авах, хөрөнгө оруулах замаар хяналтын багц буюу 51 хувийг өөртөө нэгтгэлээ.

	ЭЗЭМШЛИЙН ХУВЬ	
	Өмнө	Одоо
Тэсо инвестмент	80.0%	39.1%
Мөнжаргал	20.0%	9.8%
Монложистикс холдинг ХК	-	51.1%
<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>100%</b>

### Төв Азийн Зам компанийн танилцуулга

“Төв Азийн Зам” ХХК нь тээвэр ложистикийн чиглэлээр 2012 онд ТЭСО Инвестмэнт ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан. Өдгөө 12 дахь жилдээ тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй тус компани 30 гаран ажилтантай салбарын тэргүүлэгч компанийн нэг болсон байна.

### Яагаад хөрөнгө оруулалт хийх болов?

Төв Азийн Зам ХХК нь суудлын авто машины импортын тээврийн зах зээлд томоохон байр суурь эзэлдэг мэргэжлийн хамт олонтой компани. Зах зээл болон компанийн бизнесийн өсөлт нь тасралтгүй үргэлжилж байгаа Төв Азийн Зам ХХК-г Монложистикс Групп нь өөрт нэгтгэснээр богино хугацаанд том зах зээлээс шууд ашиг хүртэх боломж бүрдэж байгаагаараа онцлогтой.

Монгол улсын нийт импортын 20%-ийг дангаараа бүрдүүлдэг суудлын автомашины зах зээл нь улсын хэмжээнд хамгийн их импортлогддог бараа бүтээгдэхүүний хоёрдугаарт ордог томоохон зах зээл юм. Уг зах зээл өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд эрчимтэй өсөж, 2024 оны эхний хагасын байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 105%-р өссөн үзүүлэлттэй байна.

### Хөрөнгө оруулалтын хүлээлт


Төв Азийн Зам компанийг нэгтгэх ажлыг 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс эхэлж тооцохоор гэрээнд тусгасан бөгөөд Монложистикс Группийн 2024 оны нэгтгэл санхүүгийн тайланд “Төв Азийн Зам” ХХК-ийн гүйцэтгэл бүтэн дүнгээр нэгтгэгдэж орно.

Уг нэгтгэлийн үр дүнд Монложистикс группийн борлуулалтын орлого 15%-20%, хүлээгдэж буй цэвэр ашиг 10%-15%-иар нэмэгдэх эерэг хүлээлттэй байна.

Түүнчлэн Монложистикс Групп нь үндэсний топ группүүдийн нэг болох ТЭСО Групптэй бизнес хамтрагч болсноор цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлж, олон шинэ боломжуудыг нээх гарц үүсэж байна.

**MLG**  
Монложистикс групп

**CAR**  
Төв азийн зам



02

**СТРАТЕГИ БОЛОН  
САНХҮҮГИЙН ЗОРИЛГО**

## АЛСЫН ХАРАА 2030

Бид орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол улсыг Ази, Европыг холбосон ложистик төв болгоно.

Уг алсын харааг биелүүлэх урт хугацааны стратеги, зорилгын хүрээнд дараах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.




# БИЗНЕС МОДЕЛЬ

Олон улсад нийлүүлэлтийн сүлжээг удирдах хэлбэр 1PL загвараас 5PL хүртэл хөгжөөд буй бөгөөд Монложистикс Группийн хувьд өөрийн харилцагч байгууллагуудын ачааг тээвэрлэх тээврийн шинэ маршрутыг хөгжүүлснээр геополитикийн хүндрэлээс үүсэж буй тээвэрлэлтийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, хамтран ажиллагч түншийн харилцаа болон дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлснээр тээвэрлэлтийн хямд бөгөөд хурдан шуурхай үйлчилгээг санал болгож, өөрийн 3PL бизнес моделийг хөгжүүлэн ажиллаж байна.

**3PL** загвар нь ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний олон асуудлыг хариуцдаг мэргэжлийн ложистикийн үйлчилгээ үзүүлэгч компаниас Ачааг хүлээн авах, Тээвэрлэх, Хадгалах, Савлах, Шошголох, Хүргэлт хийх гэх мэт үйлчилгээг авч байгаа хэлбэр юм. 3PL үйлчилгээ үзүүлэгчид нь илгээгч болон тээвэрлэгчдийн хооронд зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэж, үр ашгийг оновчтой болгох, зардлыг бууруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлтийн гинжин хэлхээний ложистикийг удирддаг.

3PL үйлчилгээ үзүүлэгч компаниудын үйлчилгээг ашигласнаар бизнес эрхлэгчид үндсэн бизнестээ анхаарлаа төвлөрүүлж, ложистикийн хэрэгцээгээ туршлагатай мэргэжилтнүүдэд даатгаж чаддаг.



## Олон улс дахь тээвэр ложистикийн үйлчилгээ

Тээврийн захилга - Ачааг агуулахаас авах үйлчилгээ - Агуулах  
 Бичиг баримт болон гаалийн үйлчилгээ - Цуглуулбар ачааны тээвэр  
 Худалдан авалтын захиалгын үйлчилгээ - Түр агуулахын үйлчилгээ  
 - Даатгал



**Тээвэр**  
Туслан гүйцэтгэгч

## Монгол улс дахь тээвэр ложистикийн үйлчилгээ

Агуулах - Хүргэлт ба савлах - Түр агуулахын үйлчилгээ  
 Цуглуулбар ачааны түгээлт - Хаягжуулалт - Түгээлт - Бичиг  
 баримт болон гаалийн үйлчилгээ - Цахим худалдааны түгээлт -  
 Нүүрстөрөгчийн ялгаруулалтын тайлан - Нийлүүлэлтийн сүлжээний  
 инновац - 4PL үйлчилгээ



**Илгээгч**

**Бидний гол нөөц**

**Хүлээн авагч**

Баг хамт олон - IT систем - Салбарын туршлага - Стандартын дагуух процесс үйл ажиллагаа - Тээвэрлэгчийн түншлэл - Олон улс дах салбар байгууллага

■ Бидний үзүүлдэг үйлчилгээ

■ Үзүүлэхээр төлөвлөж буй үйлчилгээ

# 2024 ОНЫ ЗОРИЛТ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монложистикс группийн 2024 онд төлөвлөгөөний биелэлтийн хүлээгдэж буй үр дүн хэвэндээ байна.

## 2024 оны санхүүгийн төлөвлөгөө

Хүлээлт 2024 (тэрбум.төгрөг)	2023 гүйцэтгэл	2024 төлөвлөгөө	2024 хүлээлт
Цэвэр ашиг	8.4	13-15	13-15
Цэвэр ашгийн хувь	4.1%	5%-5.5%	5%-5.5%

## 2024 оны санхүүгийн төлөвлөгөөний суурь таамаглал

Бидний 2024 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан суурь эдийн засгийн гүйцэтгэл хүлээлтийн дагуу байна. Харин голлох валютын ханшийн өсөлт хүлээлтэд хүрээгүй хэдий ч, ложистикийн салбарын өсөлт бидний хүлээлтээс давсан үзүүлэлттэй байна. Монложистикс групп нь дотооддоо шинээр хөгжүүлэх болон зах зээл дээр хэдийн байршсан компани худалдан авах арга замуудаар зах зээлийн эзлэх байр сууриа тэлэхээр төлөвлөн ажилласаар байна. Энэхүү ажлын эхлэл болох болох Төв Азийн Зам ХХК-ийн 51%-ийг хувьцааг худалдан авснаар группийн хүлээгдэж буй ашгийг нэмэгдүүлж байна. Энэхүү М&А-ийн худалдан авалтын өдрийг 2024 оны 1-р сарын 1 байгаа нь тус компанийн 2024 гүйцэтгэл бүтэн дүнгээр нэгтгэсэн тайланд тусгагдах юм.

Алсын хараа 2030 төлөвлөгөөний дагуу Монложистикс Групп нь 2024 оны сүүлийн хагаст БНХАУ-д салбар байгуулах, экспортын тээврийн өргөжүүлэлт болох вагоны хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, дараагийн М&А судалгаа зэргийг төлөвлөөд байна.

## Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын дүн (сая.төгрөг)	Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл
Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	398	4,164
Эргэлтийн хөрөнгө	2,923	2,878	45
Төв азийн зам ХХК		3,500	
<b>Нийт</b>	<b>10,985</b>	<b>6,778</b>	<b>4,207</b>

## Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт

Бид экспортын тээврийн үйл ажиллагааг өргөжин тэлэхэд зориулж, 2 цуваа буюу 100 ширхэг 13-6953 загварын тавцант вагоныг ОХУ-аас худалдан авахаар төлөвлөсөн. Төмөр замын тухай хуулийн хэрэгжилт хойшилсон болон мөн ОХУ-аас вагон худалдан авах үйл ажиллагаанд учирч буй саад бэрхшээлээс үүдэн вагоны хөрөнгө оруулалтын хугацаа, вагоны төрөлд өөрчлөлт оруулсан юм.

Эхний 10 ширхэг 12-1293 загварын хагас вагон нь 2024 оны 8-р сард Монгол улсад импортлон орж ирэхээр байна. Дараагийн 40 ширхэг вагоны гэрээ хэлэлцээрийн шатанд явж байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар эхний 10 ширхэг вагоны нийт хөрөнгө оруулалт 1.6 тэрбум нь зээлээр, 0.45 тэрбум төгрөг нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулагдсан байна. Үлдэгдэл төлбөр хөдлөх бүрэлдэхүүн Монгол улсад орж ирснээр төлөгдөх юм.

## Эргэлийн хөрөнгийн санхүүжүүлэлт

Охин компаниудын өсөлтийг хангахын тулд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 2.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

## Шинэ бизнес: М&А - Төв Азийн Зам ХХК

Монложистикс групп нь зах зээл дээр хэдийн байршсан компани худалдан авах замаар зах зээлд эзлэх байр сууриа тэлэхээр сүүлийн жилүүдэд хурдтай өсөж буй ТЭСО группийн охин компани болох Төв Азийн Зам ХХК-ийг 51%-ийг худалдан авахад 3.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулсан байна.



**03**

**БИДНИЙ ҮЙЛ  
АЖИЛЛАГАА**




# Үйл ажиллагааны тайлан

- > Тээврийн салбарын нийт орлого
- > Монложистикс Группийн орлого
- > Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ
- > Монложистикс Группийн ачааны хэмжээ

## МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО II УЛИРАЛД 49.1% НЭМЭГДЭЖ ₮141.9 ТЭРБУМД ХҮРЛЭЭ.

### ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО

/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




2024 оны 2-р улирлын байдлаар тээврийн салбарын орлого 3.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 25.4% өссөн байна.

“Эх сурвалж : Үндэсний Статистикийн хорооны мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн дотоод судалгаа болно.”


### МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО

/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




2024 оны 2-р улирлын байдлаар Монложистикс Группийн орлого өмнөх оны мөн үеэс 55%-иар өсөж 141.9 тэрбум төгрөг болж өссөн байна.

### ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



Тээврийн салбарын 2024 оны 2-р улирлын байдлаар нийт ачаа тээврийн эргэлтийн хэмжээ 58.2 сая.тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 27.1% өссөн байна.


### МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



Монложистикс группийн ачаа эргэлт 570 мян.тн хүрч өмнөх оны мөн үеэс 12.8% өссөн үзүүлэлттэй байна.


## ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /





## ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



## ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



## ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



**04**

**ТОГТВОРТОЙ  
ХӨГЖИЛ**

## EMPLOYEE DAY 2024

### “ҮНЭ ЦЭНТЭЙ АЖИЛТАН, ҮНЭЛШГҮЙ ҮР ДҮН”



Ажил олгогчийн брэндингийг дотооддоо таниулах замаар, нийт ажилтнуудын сэтгэл ханамжтай, бүтээмж өндөр, тогтвортой ажиллахад нөлөөлж, нээлттэй хувьцаат компанийн ил тод байдалд тулгуурлан, зах зээлийн тэргүүлэгч байгууллагын бизнесийн алсын харааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ажилтан бүрийн оролцоог нэмэх зорилгоор Монложистикс Групп нь 4 дэх жилдээ “EMPLOYEE DAY” арга хэмжээг 7 өдрийн турш амжилттай зохион байгууллаа.



Уг арга хэмжээгээр бид Группийн нийт ажилтнуудын санхүүгийн боловсролд мэдлэг олгох үүднээс “Хөрөнгө оруулалт, хувьцаа, цалин хангамж” сэдвүүдээр хамгийн сүүлийн үеийн сургалт мэдээллийг өгч, Монос хүнс компанитай хамтран ажилтнуудын эрүүл мэндийн олон талын үзлэг шинжилгээ хийгдэж, зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн ажилтнуудынхаа эрүүл мэндийг тогтвортой байлгах зорилгоор бүх ажилтнуудад 300,000₮ олгож, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, витаминжуулахыг 1 удаа уриалж, идэвхжүүлж ажиллалаа.



2023 оны 9-р сараас нээлттэй хувьцаат компани болсонтой холбогдуулан Группийн нийт ажилтнуудад олон улсын компанийн засаглалын кодексийн шаардлага, стандартыг ойлгуулж, бүх ажилтанд мэдлэг олгох нээлттэй сургалт хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа. Монложистикс Групп нь 2024 оны 1-р сараас Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлж уг өдөрлөгөөр “Дээд удирдлагын тунхаглал, чанарын бодлого”-ыг бүх нийтэд танилцуулах ажил хийгдлээ.





## МЕНЕЖМЕНТ ФОРУМ

Монложистикс Группийн удирдлагын залгамж халааг хөгжүүлэн бэлдэх зорилгоор 3 дахь жилдээ Группийн нийт удирдлагын багийн ажилтнуудыг хамарсан Менежмент форумыг 1 сарын турш цогц хөтөлбөрөөр амжилттай зохион байгууллаа.

Уг хөтөлбөрөөр АПУ ХК-ийн Стратеги төлөвлөлтийн захирал, Шунхлай ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Компаниудын ТУЗ, Мэргэжлийн холбоод, ТББ-ын удирдах зөвлөлд ажилласан туршлагатай Менежментийн зөвлөх П.Батхишиг захирлаар удирдуулсан сургалт зөвлөгөө CEO&Стратеги сэдвийн хүрээнд явагдлаа. Мөн Дэйл Карнеги компанийн Гүйцэтгэх захирал А.Даваасүрэн захирлын бизнес хэлэлцүүлгээр удирдлагуудын мэдлэг чадварыг сорьсон юм.



## “FUTURE CEO 2” ХӨТӨЛБӨР

Монложистикс Групп нь Тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын хүрээнд 2 дахь жилдээ оюутан залуусын дунд 100% тэтгэлэгт, цалинтай хөтөлбөрөө зарласан юм.

Хөтөлбөрийн зорилго: Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэ цэн бүтээх, ирээдүйн манлайлагчдыг төрүүлэхэд бодит дэмжлэг болж, оюутан залуусын академик амжилтыг карьер амжилт болгох дээр дэмжиж ажиллана.

2024-2025 онд анх удаа бакалаврын 3, 4-р курстээ элсэн суралцах гэж буй 3 оюутанд 100% их сургуулийн сургалтын тэтгэлэг, цалинтай ажлын байр олгох бөгөөд энэ удаа бид ирээдүйд олон улсын зах зээлд ажиллах гадаад хэлтэй мэргэшсэн оюутан залуусыг онцолж байгаа юм.

## KESO ХӨТӨЛБӨР

KESO гэдэг нь Key Employee Stock Option үгний товчлол бөгөөд Гол ажилтанд опцион хэрэгжүүлэх буюу байгууллагын менежерээс дээш түвшний нийт удирдлагын шатны ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр юм.

Уг хөтөлбөрт хамрагдах эсэх нь ажилтны өөрийн хүсэл шийдвэр байх бөгөөд байгууллагын зүгээс Группийн удирдлагын багийн бүтэц бүрэлдэхүүнийг тогтвортой, хамгийн өндөр бүтээмжтэй ажиллуулахад хөтөлбөрийн гол ач холбогдол оршино. Дэлхийн томоохон хөгжилтэй орнуудад уг хөтөлбөр амжилттай хэрэгжиж, байгууллага болон ажилтан аль аль талдаа ашигтай, харилцан үйлчлэл болон хөгжсөөр байна.

Харин манай улсын хувьд шинэхэн ойлголт хэвээр байгаа бөгөөд Монложистикс Групп нь хууль эрх зүйн орчны өөрчлөлтийг даган энэхүү хөтөлбөрийг амжилттай батлуулж, ажилтнуудтай гэрээ 4 жилийн гэрээ байгуулан ажиллаж байна.



## САНХҮҮГИЙН УЛСЫН Х ОЛИМПИАД

2024 оны 4-р сард Санхүүгийн Менежментийн Улсын Х Олимпиадад 8 их, дээд сургуулийн 13 багийн шилдэг 65 оюутан өөрсдийн мэдлэг, багаар ажиллах ур чадвараараа өрсөлдлөө.

Түүнчлэн энэхүү олимпиадыг Монголын топ аж ахуйн нэгжүүд ивээн тэтгэж, оюутнуудын ирээдүйд өндөр хувь нэмэр оруулсан бөгөөд Алтан спонсороор Монложистикс Холдинг ХК ажиллалаа.

Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл” үнэт зүйлсийнхээ хүрээнд Монложистикс Групп аливаа бизнес дээр гарч ирэх оюуны өндөр ур чадвартай, хичээл зүтгэлтэй зөв залуусыг үргэлж дэмжиж ажилладаг бөгөөд тэргүүн байранд шалгарсан багийг урьж, Монложистикс Групптэй танилцуулах ажлыг зохион байгууллаа. Мөн тэдний өмнө тээврийн салбарын тэргүүлэгч компанийн үүд хаалга үргэлж нээлттэйг баяртайгаар дуулгасан юм.

**05**

**ЗАСАГЛАЛ**



## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

**Монложистикс Холдинг ХК**

Хэлбэр:

**Нээлттэй хувьцаат компани**

Регистрийн дугаар:

**6381251**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

**Монголын Хөрөнгийн бирж**

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:

**Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс**

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:

**395,858,822**

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:



**Тээвэр ложистик, Менежментийн зөвлөх үйлчилгээ**

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ:

**Хувьцаа эзэмшигчдийн тоо:**



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



# ЗАСАГЛАЛ

## I. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Монложистикс Холдинг ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 85.57%-ийн ирцтэйгээр хуралдсан. Хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хуралд:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г.Хишигбат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг товч танилцуулж;
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг компанийн ТУЗ-ийн цалингийн төсвийг хэлэлцэж батлахын өмнө компанийн ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж;
3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцсон.

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар

1. Монложистикс Холдинг ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батласан.
2. Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батласан.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Лувсанжамба  
ГАНЗОРИГ**

Үүсгэн байгуулагч,  
ТУЗ-ийн дарга  
НДБЦУХорооны гишүүн  
СБХХорооны гишүүн

- Засаглал, удирдлага
- Санхүү, олон улсын худалдаа
- Стратеги, менежмент
- 30+ жилийн туршлагатай



**Бааст  
ТЭЛЭНГЭД**

Үүсгэн байгуулагч,  
ТУЗ-ийн ердийн гишүүн  
СБХХорооны гишүүн

- Тээвэр ложистик, олон улсын худалдаа
- Санхүү, стратеги менежмент
- 30+ жилийн туршлагатай



**Өлзийбаяр  
ГАНЗОРИГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
СБХХорооны гишүүн

- Санхүү, нягтлан бодох бүртгэл, хөрөнгө оруулалт
- Засаглал, стратеги, менежмент
- 20+ жилийн туршлагатай



**Ганзоригт  
ХИШИГБАТ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Санхүү, хөрөнгө оруулалт
- Засаглал, стратеги, менежмент
- 15+ жилийн туршлагатай



**Балдан  
ЭНХТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн  
АЭУХорооны гишүүн

- Санхүү, нягтлан бодох бүртгэл, даатгал
- Засаглал, стратеги, менежмент
- 20+ жилийн туршлагатай



**Эрэндоо  
ОЮУНБИЛЭГ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
АЭУХорооны дарга  
НДБЦУХорооны гишүүн

- Засаглал, комплайнс, менежмент
- 30+ жилийн туршлагатай



**Санжаа  
САЙНБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
СБХХорооны дарга  
АЭУХорооны гишүүн

- Засаглал, удирдлага
- Стратеги, санхүү, менежмент
- 25+ жилийн туршлагатай



**Готов  
ЦЭРЭНПҮРЭВ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
СБХХорооны гишүүн

- Санхүү, банкны менежмент
- Засаглал, стратеги, менежмент
- 40 жилийн туршлагатай



**Сэнгээ  
ЭНХ-АМГАЛАН**

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
НДБЦУХорооны дарга

- Бизнесийн удирдлага
- Засаглал, стратеги, менежмент
- 20+ жилийн туршлагатай



**Цогт ДУЛАМСҮРЭН**

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга бөгөөд Нийцэл хариуцсан ажилтан

- Захиргаа, хүний нөөц, эрх зүй
- Засаглал, бизнесийн удирдлага
- 20+ жилийн туршлагатай

## II. Төлөөлөн удирдах зөвлөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм. Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 5, хараат бус 4, нийт 9 гишүүнтэй.

## III. ТУЗ-ийн ажлын товч тайлан

ТУЗ нь 2024 оны эхний хагас жилд 2 удаа ээлжит, 2 удаа ээлжит бусаар буюу нийт 4 удаа хурал хуралдуулж, Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 28 шийдвэр гаргасан. ТУЗ-ийн 3 удаагийн хурлын ирц 100%, 1 хурлын ирц 89%-тай, хурлын дундаж ирц 97.25% байсан.

### ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2024 оны эхний хагас жилд биечлэн болон цахим хэлбэрээр:

- Аудит, эрсдэлийн удирдлагын хороо 3 удаа;
- Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 2 удаа;
- Стратеги, бизнес хөгжлийн хороо 4 удаа тус тус хуралдаж, хороодын чиг үүргийн дагуу хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гарган ажилласан.

ТУЗ-ийн гишүүдийн сургалтын хөтөлбөрийн дагуу “Дижитал шилжилт” сэдвээр сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

### ТУЗ-ийн цалин, урамшуулал

ТУЗ-ийн дарга болон гишүүдийн цалингийн төсвийг 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Батлагдсан төсвийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд үндсэн цалин болон хорооны даргын нэмэгдэл, хорооны гишүүний нэмэгдлийг тус тус тогтмол дүнгээр олгож байна.

№	Зардлын задаргаа	Нийт зардал
1	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал	182,400,000 ₮
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	22,800,000 ₮
<b>НИЙТ ЗАРДЛЫН ТӨСӨВ</b>		<b>205,200,000 ₮</b>

## IV. Хяналт

### Комплайнсын хяналт

Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниудын үйл ажиллагаа болон дотоод хэм хэмжээний актуудыг хууль, эрх зүйн хэм хэмжээнд хянан нийцүүлэх замаар хууль эрх зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн гарах эрсдэлүүдээс сэргийлэх, компанид комплайнсын соёлыг бүрдүүлж төлөвшүүлэх зорилготой “Нийцлийн журам” 2024 оны 2 дугаар сард шинэчлэгдэн батлагдсан.

Компани үйл ажиллагаандаа олон улсын чанарын ISO9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2024 оны 3-6 дугаар саруудад Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниудын үйл ажиллагаа болон дотоод хэм хэмжээний актууд нь хууль, эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг үнэлж, Нийцэл хариуцсан ажилтан үнэлгээг хянан баталгаажуулж, үл нийцэл бүрд залруулах арга хэмжээний зөвлөмж гаргалаа.

2024 оны сүүлийн хагас жилд Монложистикс Холдинг ХК, түүний охин компаниуд нь үл нийцлийг үе шаттайгаар залруулах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

## V. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, өөрийн үнэлгээ

### Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх нь засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бий болгох, компанийг эрсдэлээс хамгаалж, тогтвортой үнэ цэнийг бүтээх чухал ач холбогдолтой засаглалын бодлогын бичиг баримтуудыг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилд дараах журмуудыг шинээр баталсан.

- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам
- Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого

Монложистикс Холдинг ХК нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын бичиг баримтыг батлаж, 2024 оны эхний хагас жилд чухал оролцогч тал болох хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчидтэй харилцах (investor relation) функцээ сайжруулах зорилгоор мэргэжлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний компани болох Capital Market Mongolia компанитай хамтын ажиллагааг эхлүүлсэн. Тус зөвлөх үйлчилгээний хүрээнд хөрөнгө оруулагчидтай харилцах суваг, календарь боловсруулах, хөрөнгө оруулалтын түүх, хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга, стратеги боловсруулах зэрэг цогц ажлууд хийгдэх юм.

Ингэснээр хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчиддээ олон улсын жишигт нийцсэн, илүү мэргэжлийн мэдээ мэдээллийг хүргэж, Монгол улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, дараагийн шатанд хүргэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулж байна.

Хөрөнгө оруулагчидтай харилцах дараах хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



### Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр 2024

Хөтөлбөрийн зорилго: Хөрөнгө оруулагчидтай харилцах (investor relation) функцээ сайжруулах замаар хөрөнгө оруулагчдад илүү мэргэжлийн олон улсын жишигт нийцсэн мэдээ мэдээллийг хүргэж, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хариуцах: Монложистикс Холдинг ХК-ийн Удирдлагын баг болон Capital Market Mongolia ХХК-ийн баг

№	Голлох үйл ажиллагаа	Тайлбар
1	Мэдээ, мэдээллийг тогтвор, дагтамжтайгаар нийтлэх	Онцлох үйл ажиллагаа, компанийн болон салбарын тухай сөрөнхий ойлголтууд өгөх мэдээлэл нийтлэх тэргэ өрсөн цар хуудалтай
2	Постууд оруулах	Онцлох үйл ажиллагаа, компанийн болон салбарын талаарх мэдээлэл өгөх тэргэ нэвтрүүл
3	Тайлангууд нийтлэх	Олон нийгэд танилцуулах компанийн үйл ажиллагааны тайлангууд
4	Ярилцлага, нэвтрүүлэгт орох	Нэгдэл ашиг болон жилийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны үр дүнгийн талаар нэгтгэл мэдээллийн хэрэгсэлээр ярилцлага өгөх, нэвтрүүлэгт оролох
5	Нэгдэл ашиг хуваарилалтын талаар	Нэгдэл ашиг хуваарилалтын талаар мэдээлэл өгөх (санхүү, өсөлт, хөрөнгө оруулалт)
6	Холбогдох ТУЗ-ийн шийдвэр	Олон нийгэд танилцуулах ТУЗ-ийн тогтоолуудыг танилцуулах
7	Earnings call	Мэргэжлийн оролцогчдад зориулсан үйл ажиллагаа зохион байгуулах
8	Хувьцаа эзэмшигчдийн хурал	Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах
9	Жижиг хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга	Телеграм сонголт тэргэ жижиг хөрөнгө оруулагчдын дунд нэгдэлтэй байгаагаа илэрхийлэх ажлыг зохион байгуулах
10	Хөндлөнгүйн судалгааны байгууллагын analyst coverage буюу хувьцааны судалгаа хийгдэх	Хамтын ажиллагаатай брокер, эсвэл хөндлөнгүйн судалгааны байгуулагчаар судалгаа хийгдэх

Хөтөлбөрийг боловсруулсан: М. ХОСБАЯР /Маркетингийн менежер/

Хөтөлбөрийг баталсан: Г. ХИШИГБАТ /Түргэлжлэх захирал/





# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

## Гүйцэтгэх захирал

Мэдээлэл технологийн хэлтэс

Санхүүгийн хэлтэс

Ложистикийн хэлтэс

Стратеги, бизнес хөгжлийн хэлтэс

Захиргаа, хүний нөөцийн хэлтэс

Толгой компанийн бизнесийн үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдан чиглүүлдэг ба Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад Санхүү, Мэдээлэл технологи, Стратеги бизнес хөгжил, Захиргаа хүний нөөц, Ложистик гэсэн 5 хэлтэс харьяалагддаг.



**Г. Хишигбат**

Монложистикс Холдинг ХК  
Гүйцэтгэх захирал

Санхүү, Хөрөнгө оруулалтын чиглэлээр 10 жил, засаглал гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 7 жилийн туршлагатай.



**А. Одгэрэл**

Ложистик эрхэлсэн захирал

Тээвэр ложистикийн салбарт 18 жил, засаглал, гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 7 жилийн туршлагатай.



**З. Шинэ-Од**

Санхүү эрхэлсэн захирал

Худалдаа, үйлдвэрлэл, тээврийн салбарт санхүү менежмент чиглэлээр 12 жилийн ажлын туршлагатай.



**Б. Азжаргал**

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

Олон улсын худалдаа, Хүний нөөц, засаглалын 13 жилийн ажлын туршлагатай.



**Т. Батзаяа**

Технологи эрхэлсэн захирал

Мэдээлэл технологийн салбарт 17 жилийн технологи, гүйцэтгэх удирдлагын туршлагатай.

## ОХИН КОМПАНИУДЫН УДИРДЛАГА



**Г. Хишигбат**

Гүйцэтгэх захирал  
Монложистикс Холдинг ХК

Санхүү, Хөрөнгө оруулалтаар 10 жил, засаглал удирдлагын чиглэлээр 7 жилийн туршлагатай.



**Б. Тэлэнгэд**

Гүйцэтгэх захирал  
Монложистикс Транзит ХХК

Тээвэр ложистикийн салбарт 30 жилийн туршлагатай.



**А. Одгэрэл**

Гүйцэтгэх захирал  
Монложистикс Тракинг ХХК

Тээвэр ложистикийн салбарт 18 жил, засаглал, гүйцэтгэх удирдлагын чиглэлээр 7 жилийн туршлагатай.



**Б.Мөнхжаргал**

Гүйцэтгэх захирал  
Төв Азийн Зам ХХК

Гадаад худалдаа, барилга, хөрөнгө оруулалтын чиглэлээр 10 жилийн туршлагатай.



**И.Цогбаяр**

Гүйцэтгэх захирал  
Монложистикс Ворлдвайд ХХК

Тээвэр ложистикийн салбарт 4 жилийн туршлагатай.



**Н.Эрдэнэбилэг**

Гүйцэтгэх захирал  
Каус Аустралис ХХК

Төмөр зам, тээвэр ложистикийн салбарт 30 жилийн туршлагатай.



**Тугаринов.В.А**

Гүйцэтгэх захирал  
Монложистикс Транс Сервис ХХК

Төмөр зам, тээвэр ложистикийн салбарт 14 жилийн туршлагатай.



**Ч.Золбоо**

Гүйцэтгэх захирал  
Монложистикс Карго ХХК

Тээвэр ложистикийн салбарт 4 жилийн туршлагатай.

## 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЛАА.

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн №24/ТУЗ/06 тоот тогтоолоор компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 48 /дөчин найм/ хувь буюу 3,000,609,870.76 /гурван тэрбум зургаан зуун есөн мянга найман зуун далан төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Нэгж хувьцаа тус бүрд 7.58 /долоон төгрөг тавин найман мөнгө/ төгрөгөөр тооцож ногдол ашгийг хуваарилсан.

Ногдол ашиг авах эрхтэй компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоон, ногдол ашгийг 2024 оны 04 дугаар сарын 30-ний өдрийн дотор “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулж олгосон.

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

MSE:	<b>MLG</b>
Гаргасан нийт хувьцаа:	<b>395,858,822 ширхэг</b>
2024 оны 6 сарын 27-ны хаалтын ханш:	<b>169.0</b>
Зах зээлийн үнэлгээ:	<b>66,9 тэрбум.₮</b>

Компанийн зах зээлийн үнэлгээ 2024 оны эхний хагас жилийн эцэст 66 тэрбум 900 сая төгрөгт хүрсэн байна. Тайлант хугацаанд компанийн 12,373,407 ширхэг үнэт цаас нийт 2,589,026,745 төгрөг буюу өдөрт дунджаар 96,667.24 ширхэг хувьцаа 20,226,771.45 төгрөгөөр арилжаалагджээ.

Хувьцааны хаалтын ханш:

- Дунджаар VWAP 176.11,
- Хамгийн ихдээ 204.79 төг (2024.01.04-ны өдөр),
- Хамгийн багадаа 160.5 төг (2024.06.17-ны өдөр) байв.

Монложистикс Холдинг ХК нь 2024 оны 1-р сарын 16-ны өдрөөс Монголын хөрөнгийн бирж ХК-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын дагуу ТОП-20 индексийн багцад орсон билээ.

### Хаалтын ханш



### Арилжаалагдсан хувьцааны тоо

600,000  
480,000  
360,000  
240,000  
120,000  
-

An aerial photograph of a red monlogistics truck parked in a large industrial warehouse. The truck is positioned in the center of the frame, facing downwards. The warehouse floor is marked with red lines, and several red and blue containers are visible in the foreground. The monlogistics logo is visible on the side of the truck's trailer and in the top left corner of the image.

**monlogistics**  
GROUP

**06**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

## НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2022 НI	2023 НI	2024 НI
Борлуулалтын орлого	65,875	91,497	141,982
Борлуулалтын өртөг	(58,801)	(82,663)	(130,264)
<b>Нийт ашиг</b>	<b>7,075</b>	<b>8,834</b>	<b>11,718</b>
Борлуулалт, Удирдлагын зардал	(4,007)	(3,421)	(4,156)
Бусад орлого	(3)	10	103
Бусад зардал	50	(205)	(103)
<b>Үйл ажиллагааны цэвэр ашиг</b>	<b>3,115</b>	<b>5,218</b>	<b>7,562</b>
Санхүүгийн орлого (зардал)	(96)	(58)	27
<b>Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)</b>	<b>3,020</b>	<b>5,160</b>	<b>7,590</b>
ОАТ-н зардал	(352)	(583)	(943)
<b>Цэвэр ашиг</b>	<b>2,667</b>	<b>4,577</b>	<b>6,646</b>
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	2,463	3,405	4,993
Хяналтын эрхгүй хувь оролцоо	204	1,172	1,653
<b>Бүх дэлгэрэнгүй орлого</b>			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	24
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>2,667</b>	<b>4,577</b>	<b>6,670</b>
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	2,463	3,405	5,017
Хяналтын эрхгүй хувь оролцоо	204	1,172	1,653
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>2,667</b>	<b>4,577</b>	<b>6,670</b>
<b>Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг (алдагдал)</b>	<b>6.22</b>	<b>8.60</b>	<b>12.67</b>

## НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2022 НI	2023 НI	2024 НI
Мөнгөн хөрөнгө	6,641	8,742	9,194
Дансны авлага	22,313	25,754	39,475
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-	3,195
Урьдчилж төлсөн төлбөр	8,473	7,757	19,314
Бараа материал	64	151	3,622
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	2,294
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>37,491</b>	<b>42,404</b>	<b>77,093</b>
Үндсэн хөрөнгө	1,292	1,639	1,902
Ашиглах эрх бүхий хөрөнгө	255	1,648	836
Бусад эргэлтийн бус хөрөнгө	14	56	2,629
Гудвилл	-	-	3,463
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>1,560</b>	<b>3,343</b>	<b>8,830</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>39,051</b>	<b>45,747</b>	<b>85,923</b>
Дансны өглөг	12,023	10,391	20,725
Урьдчилж орсон орлого	1,148	1,291	8,646
Богино хугацаат зээл	-	2,754	4,642
Бусад өглөг	133	486	1,250
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>13,304</b>	<b>14,923</b>	<b>35,263</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>2,025</b>	<b>1,684</b>	<b>2,905</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>15,329</b>	<b>16,606</b>	<b>38,168</b>
Эздийн өмч	22,267	26,237	41,604
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	1,455	2,904	6,150
<b>Нийт Эздийн өмч</b>	<b>23,722</b>	<b>29,141</b>	<b>47,754</b>
<b>Нийт өр төлбөр ба Эздийн өмч</b>	<b>39,051</b>	<b>45,747</b>	<b>85,923</b>



**ХАЯГ**

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

**ХОЛБОО БАРИХ**

+976 7701-5454  
info@mlholding.mn  
www.mlholding.mn